

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 1 дүгээр сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2016 оны 1 дүгээр сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1304 болж, 2015 мөн үеэс 712 хүнээр, өмнөх сарынхаас 455 хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 46.55 хувь буюу 607 нь эмэгтэйчүүд юм. 2016 оны эхнээс 128 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 110 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 38.18 хувь буюу 42 нь эмэгтэйчүүд байв. Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 1 дүгээр сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 762 ажилгүй иргэний 30.45 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 28.87 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 12.86 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 6.3 хувь нь шилжин суурьшсан; 3.67 хувь нь орон тооны цомхтголд орсон; 3.28 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 2.36 хувь нь байгууллага татан буугдсан;

1.97 хувь нь цэргээс халагдсан; 1.31 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 0.92 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 0.52 хувь нь хорих газраас суллагдсан; 0.39 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.13 хувь нь тэтгэвэрт гарсан; 6.96 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 1 сард НДШ-ийн орлого 826.0 сая ₮ болж төлөвлөгөө 72.94 хувь болж, төлөвлөгөөг бүх сум 2.5-37.03 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 86.6 сая ₮ болж төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 3.13 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.9 хувийг өндөр настны, 10.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 258260 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 31.68 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 20.30%; тэтгэмжийн даатгалын сангийн 59.86%; эрүүл мэндийн даатгалын сангийн 108.36%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 270.48%; ажилгүйдлийн даатгалын сангийн 100.0%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 1 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 36292 хүнд олгож, 982.1 сая ₮-ийг зарцуулж 2015 оны мөн үеэс хүний тоо 3.48 хувь 1300 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 5.64 хувь 58.7 сая ₮-өөр буурлаа.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 100050 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 60.3 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 22.3 хувийг халамжийн тэтгэвэр; 6.6 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.1 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.7 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 1.0 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.7 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.



1.3 Эрүүл мэнд

2016 оны эхний 1 сард 10590 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.64 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 1 сард 114 хүүхэд мэндэлсэн нь 2015 оны мөн үеэс 21 хүүхдээр өслөө.


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Аймгийн хэмжээнд Он гарсаар 1-4 хүртэл насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 4 хүүхдээр өслөө.


Зураг 1.4

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



2016 оны эхний 1 сард халдварт өвчнөөр 91 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 1.0 дахин буюу 46 хүнээр өслөө. 2015 оны мөн үеэс салхин цэцэг 8 дахин, вируст хепатит, тэмбүү, заг хүйтэн 1.0 дахин, бусад өвчлөл 33.3 хувь тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 10 байгаа бол: Зуунмод 36, Мөнгөнморьт 20, Угтаал 15, Баянцагаанд 11 ногдлоо. Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



1.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

Цаг агаарын тойм

Төв аймгийн 2016 оны 1 сарын цаг агаарын байдлыг

олон жилийн дундажтай харьцуулсан тойм

- агаарын дундаж температур 20-31 градус хүйтэн буюу нийт нутгаар хүйтэн байв.

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур 4-16 градус хүйтэн буюу Өндөрширээт, Лүн, Бүрэн, Угтаал, Алтанбулагт 14-16 градус, Дэлгэрхаан, Эрдэнэсант орчмоор 4-6 градус хүйтэн байв.

-шөнийн хугацаанп ажиглагдсан агаарын хамгийн бага температур -34-44 градус хүйтэн буюу Заамар, Эрдэнэсантад 34 градус, Бүрэн, Алтанбулаг, Батсүмбэр, Баян-Өнжүүл, Лүн, Өндарширээтэд 41-44 градус хүйтэн.

-бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 0,0-4,3 мм, үүнээс хамгийн их нь Батсүмбэрт 4,3 мм, Борнуурт 3,1 мм, Жаргалантад 2,6 мм, Дэлгэрхаанд 1,9 мм, Баянчандманьд 1,8 мм цас оржээ.

-салхины их хурд нийт нутгаар 6-12 м/с, зарим газраар түр зуур 13-15 м/с хүрлээ.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

Цаг агаарын үзүүлэлтүүдийг 2015 оны 1-р сартай харьцуулахад:

-агаарын дундаж температур бүх нутгаар 6-13 градусаар хүйтэн

-өдрийн хамгийн их температур бүх нутгаар 6-20 градусаар хүйтэн

-шөнийн хамгийн бага температур бүх нутгаар 3-14 градусаар хүйтэн ажиглагдсан

2016 оны 1-р сард газар тариалангийн зарим нутаг, Бүрэн, Зуунмод, Батсүмбэр, Баянжаргалан орчмоор 0,2-3,7 мм-ээр ахиу, бусад сумдад ойролцоо буюу бага цас орж,

нийт нутгаар жиндүү хүйтэн, 1-13 см-ээр илүү цасан бүрхүүл тогтож, нягтарч хатуурсан байна. 2 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын температур ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим, цас нутгийн зүүн хэсгээр ахиу, бусад нутгаар орчим орох ба ихэнх сумдын нутгаар малын бэлчээрлэлт хүндрэх, саатах нөхцөл үүсэх төлөвтэй тул сумдууд нутгийн өвс тэжээлийн хүрэлцээ, хангалтыг сайтар тооцоолох, өвс тэжээл нийлүүлэх, зөөвөрлөх, хуваарилах, хүртээх ажлыг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Цаашид цас орж, цасны зузаан нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлөхөөр байна. Мөн үе үе цасан шуурга шуурч, малын хариулга маллагаа болон зам тээврийн ажилд хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.

2016 ОНЫ ХОЁРДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар. Энэ сарын агаарын температурын дундаж нь 15-20 градус хүйтэн буюу дунджийн орчим байх төлөвтэй.

Хүйтний эрч сулрах үе: Хоёрдугаар арав хоногийн эхний хагаст болон гуравдугаар арав хоногийн сүүлчээр хүйтний эрч суларч томоохон голын хөндийгөөр шөнөдөө 21-26 градус, өдөртөө 9-14 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 15-20 градус, өдөртөө 4-9 градус хүйтэн байна.

Хүйтний эрч чангарах үе: Нэг ба гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч чангарч томоохон голын хөндийгөөр шөнөдөө 31-36 градус, өдөртөө 17-22 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 24-29 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн байна.

Бусад хугацаанд: Томоохон голын хөндийгөөр шөнөдөө 24-29 градус, өдөртөө 12-17 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 18-23, өдөртөө 8-13 градус хүйтэн байна.

Энэ сард орох хур тунадас нь аймгийн зүүн хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй. Дундаж нь нутгийн зүүн өмнөд хэсгээр 0.2-1.5 мм, бусад нутгаар 1.5-2.5 мм орчим.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр нутгийн хойд хэсгээр, хоёрдугаар арав хоногийн сүүлийн хагаст ихэнх нутгаар цас орох төлөвтэй. Салхи нэг ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 12-14 м/с, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуур 16-18 м/с хүртэл ширүүсч цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

2 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын температур ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим, цас нутгийн зүүн хэсгээр ахиу, бусад нутгаар орчим орохоор байна. Цаашид цас орж, цасны зузаан нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлөхөөр байна. Мөн үе үе цасан шуурга шуурч, малын хариулга маллагаа болон зам тээврийн ажилд хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.

2016 ОНЫ ГУРАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Энэ сарын агаарын температурын дундаж нь 5-10 градус хүйтэн буюу дунджийн орчим байна. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу орох төлөвтэй.




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 1 сард аймгийн хэмжээнд 78 гэмт хэрэг бүртгэгдэж 51 хүн холбогдож иргэдийн өмчид 150.8 сая ₮-ийн хохирол учирлаа.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Гарсан гэмт хэргийн 51.3 хувь нь хулгай, 21.8 хувь нь иргэний эрүүл

мэнд эрх чөлөөний эсрэг хэрэг, 9.0 хувь нь замын осол, 2.6 хувь нь танхай дээрэм, 1.3 хувь нь хүн амины хэрэг, 0.0 хувь нь өмчийн, 14.1 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баянхангай, Баянжаргалан, Аргалант, Баян сумд 18 дээш насны 10000 хүнд 47-22 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (13)-аас харьцангуй их гарлаа

Зураг 1.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр



Гэмт хэргийн тоо 2015 оны мөн үеэс 2 хэргээр өслөө.

Зуунмод суманд 3 эмэгтэй, 53 эрэгтэй нийт 56 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2015 оны мөн үеэс 26 хүнээр буурлаа. 18 хүн баривчлагдлаа.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2016 оны эхний 1 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 264 гүйцэтгэх хуудсанд нийт 1.69 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс биелүүлбэл зохих 264 гүйцэтгэх хуудасны 1.69 тэрбум ₮-өөс 37 хуудасны 86.4 сая ₮-ийг биелүүлж, бодит

биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 14.02 хувь, үнийн дүнгээр 5.10 хувь болж 2015 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 0.85 нэгжээр өсч, үнийн дүнгийн биелэлт 7.42 нэгжээр буурлаа.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 оны эхний 1 сард кассын орлого 33.8 тэрбум ₮, кассын зарлага 34.5 тэрбум ₮ болж, гүйлгээнд 5.1 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 29798, зээлийн багцын дүн 106.0 тэрбум ₮, зээл авсан зээлдэгийн тоо 8708, олгосон зээлийн дүн 14.7 тэрбум ₮ боллоо.

Иргэдийн хувийн хадгаламжинд 1 сарын 31-ний байдлаар хугацаатай хадгаламж 7.5 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 33.1 тэрбус ₮ байна.

Харилцах дансны үлдэгдэл 1 сарын 31-ны байдлаар 172507 иргэний 5.5 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 0.76-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2016 оны эхний 1 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 536.8 сая ₮, зарлага 4.5 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 69.91 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; Хувь хүний орлогын албан татвар, өмчийн татвар, бусад албан татвар, төлбөр, хураамж, бусад орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2015 оны мөн үеэс 3.0 хувь буюу 16.6 сая ₮-өөр буурлаа. Аймгийн төсвийн орлогын 89.6 хувийг татварын, 10.3 хувийг татварын бус орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс татварын орлого 19.4 нэгжээр өч, татварын бус орлого 19.2 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 0.1 нэгжээр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 611.7 сая ₮ болж аймгийнх 481.4 сая ₮ буюу 78.70 хувь, сумынх 55.4 сая ₮ буюу 9.06 хувь, улсынх 74.9 сая ₮ буюу 12.24 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2015 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 18.1 хувь буюу 188.3 сая ₮-өөр буурч 850.3 сая ₮ болж, авлага 14.4 хувь буюу 17.1 сая ₮-өөр буурч 118.4 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 487.1 сая ₮ болж, төлөвлөгөө 67.47 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 55.4 сая ₮ болж, төлөвлөгөө 71.57 хувь биелж, Угтаал, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Эрдэнэ, Эрдэнэсант, Батсүмбэр, Жаргалант, Мөнгөнморьт, Баянцагаан, Баянхангай, Аргалант, Алтанбулаг,

Зуунмод, Сэргэлэн, Архуст, Баянцогт, Бүрэн сумд 80.21-2.24 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 481.3 тэрбум ₮ болж 69.73 хувь биелж Заамар, Өндөрширээт, Угтаал, Дэлгэрхаан, Баянчандмань, Эрдэнэсант, Эрдэнэ, Баянцагаан, Баян, Баянцогт, Зуунмод, Архуст, Сүмбэр, Аргалант, Батсүмбэр, Жаргалант, Борнуур, Баянжаргалан, Баяндэлгэр, Бүрэн сумд төлөвлөгөө 75.9-12.0 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2016 оны 1 дүгээр сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 62.39%, өмнөх оны мөн үеэс 6.68%, өмнөх сараас 0.93 хувиар тус тус өсөв.

Бараа, үйлчилгээний бүлэг	2016 оны 1 сард	
	пунктээр	хувиар
Бүгд	0.93	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.09	9.97%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.06	6.15%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.18	19.39%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.08	8.52%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.54	57.72%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	-0.04	-3.77%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	2.02%

ХҮИ-ийн 2015 оны 1 дүгээр сарын 0.93 хувийн өсөлтийн 0.54 нэгж (57.72%) нь тээврийн бүлгийн; 0.18 нэгж (19.39%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн; 0.09 нэгж (9.97%) нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн; 0.08 нэгж (8.52%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0,06 нэгж (6.15%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0.02 нэгж (2.02%) нь бусад

бараа үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс тус тус шалтгаалжээ.

ХҮИ өмнөх оны мөн үеэс 6.68% өссөний дотор боловсролын үйлчилгээний бүлэг 32.5%; хувцас бөс бараа гутлын бүлэг 11.2%; тээврийн бүлэг 9.96%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 8.7%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 6.48%; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 4.87%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 2.86%; амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 0.19%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 4.02%-аар тус тус өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 3.1%; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.58%-аар тус тус буурч зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байв.

Зураг II.4



II.5 Аж үйлдвэр

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2016 оны эхний 1 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 439.77 сая ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оны мөн үеэс 24.4 хувь буюу 86.14 сая

₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцогт, Баянцагаан, Эрдэнэ, Батсүмбэр, сумд 46.27-2.39 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 81.45) хувийг эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2015	2016	2015	2016	Дунд зогсох % Percentage share to total		2016% 2015%
	I	I	II	II	2015-II	2016-II	
Нийт дүн	353.63	439.77	353.63	439.77	100.0	100.0	124.4%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying		7.77		7.77	0.00%	1.77	
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	161.42	243.82	161.42	243.82	45.65	55.44	151.0%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	192.21	188.18	192.21	188.18	54.4	42.79	97.9%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл, ус, ариутгал хангамжийн үйлдвэрлэл өмнөх оноос 19.4 дахинаас-5.5 хувь буюу 114.13-0.95 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.


Зураг II.6 Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 1 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч

42.79, боловсруулах үйлдвэрлэл 55.44, ашигт малтмал олборлолт 1.77 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар



II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 1 сард 15.3 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 9.2 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.62 хувь буюу 6.76 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 5.8 сая ₮ болсон ба нийт орлогын 73.29 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 26.70 хувийг албан бичгийн, 12.57 хувийг зорчигчдын, 60.73 хувийг бусад орлого бүрдүүллээ.

Зураг II.10 Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 оны эхний 1 сарын мэдээгээр нийт 32 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 52; үүнээс тохирлын гэрчилгээ 48, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 4; цулын хэмжүүр 59, үүнээс жин 50, туухай 9, тус бүр баталгаажуулсан байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 1 сард нийт 680 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 62; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 358; бэлэглэлийн гэрээ 13; худалдах, худалдан авах гэрээ 22; өв залгамжлал 3; барьцааны гэрээ 157; бусад бүртгэл 65 тус бүр бүргүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 1 сард нийт 8 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 4; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 1; гишүүдэдээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 1; шашин 1; төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар /ТБАГУТҮГ/ 1 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 оны 1 сарын мэдээгээр 24 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 2; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 7; удирдлага өөрчлөгдсөн 5; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 5;

дүрмийн сан нэмэгдсэн 3; татан буугдсан 1; нэр өөрчлөгдсөн 1 тус бүр бүртгүүллээ.